



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 515

Улаанбаатар хот

“Арилжаа импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчээс
Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх,
хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Арилжаа импекс” ХК-ийн нийт гаргасан 305,248 ширхэг хувьцааны 67,28 хувь буюу 205,382 ширхэг хувьцааг эзэмшигч “Улаанбаатар хивс” ХК-иас компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 32,72 хувь буюу 99,866 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 /хоёр зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Арилжаа импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигч “Улаанбаатар хивс” ХК-иас бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа журмын дагуу нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримтлаж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000870